



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ар Ус Ундарга ОНӨХХК-ний 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/08/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn
Архангай аймаг
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Ахлах аудитор Н.Алтантуяа
Утас: 7033-3019
Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	7
3.1 Төлбөрийн акт.....	7
3.2 Албан шаардлага	7
3.3 Зөвлөмж.....	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhantai@audit.gov.mn

2024.03.15 № 157

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ар Ус Ундарга ОНӨХХК-ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Ар Ус Ундарга” ОНӨХХК-ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчлүүд нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө нь дангаараа болон нийт дүнгээрээ өргөн тархаагүй гэж үзсэн тул Хязгаарлалттай дүгнэлт хүргүүлж байна. Үүнд:

1. Тайлант онд 39,089.1 мянган төгрөгийн авлага, 22,772.0 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээг авч ажиллаагүй.
2. Компаний санхүүгийн тайлан дахь 32,601.6 мянган төгрөгийн авлага нь тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй хууль хяналтын байгууллагаар шалгагдаж байна.
3. Тайлант онд 5,232.4 мянган төгрөгийн шатахууны жолоочийн тооцооны хуудсыг хөтлөөгүй, түүнд хяналт тавьж ажиллаагүй.
4. Тайлант онд орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, алдагдалтай ажилласан, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 347 дугаар тушаал, Засгийн газрын 311 дүгээр тогтоолыг тус тус зөрчсөн аудитын тохиолдсон байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага хүлээнэ.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	319,106,158.68	99,033,634.28
1.1.02	Дансны авлага	21,611,650.49	35,952,121.93
1.1.04	Бусад авлага	35,420,036.89	50,946,627.42
1.1.06	Бараа материал	162,210,693.83	202,013,570.53
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	315,000.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	538,663,539.89	387,945,954.16
1.2.01	Үндсэн хөрөнгө	1,149,723,089.44	1,237,804,205.65
1.2.02	Биет бус хөрөнгө	3,402,960,000.00	3,401,310,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,552,683,089.44	4,639,114,205.65
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,091,346,629.33	5,027,060,159.81
2.1.1.01	Дансны өглөг	187,951,720.60	166,938,120.60
2.1.1.03	Татварын өр	18,957,545.47	39,599,799.44
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	289,420.86	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,277,381.27	7,596,174.46
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	208,476,068.20	214,134,094.50
2.1.2.01	Урт хугацаат зээл	1,767,000,000.00	1,367,000,000.00
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	299,950,339.10	299,950,339.10
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,066,950,339.10	1,666,950,339.10
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,275,426,407.30	1,881,084,433.60
2.3.01	Өмч: - төрийн	351,271,342.52	351,271,342.52
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	206,573,729.30	206,573,729.30
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	3,395,610,000.00	3,572,348,601.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-1,137,534,849.79	-984,217,946.61
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-154,918,545.44
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-1,137,534,849.79	-829,299,401.17
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,815,920,222.03	3,145,975,726.21
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,091,346,629.33	5,027,060,159.81

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,226,878,702.22	1,572,403,351.89
02	Борлуулалтын өртөг	1,370,360,476.52	1,597,772,215.45
03	Нийт ашиг(алдагдал)	-143,481,774.30	-25,368,863.56
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүгийн орлого	8,460,105.66	20,174,672.57
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
08	Бусад орлого	64,112,836.37	8,860,806.81
08.1	Орлогын дүн	72,572,942.03	29,035,479.38
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	162,920,797.13	136,327,807.37
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	5,562,363.63
12.1	Зардлын дүн	162,920,797.13	141,890,171.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00

15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	-71,253,307.46	-12,585,400.00
17.1	Олз, гарзын дүн	-71,253,307.46	-12,585,400.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-305,082,936.86	-150,808,955.18
19	Орлогын татварын зардал	5,408,000.00	4,109,590.26
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-310,490,936.86	-154,918,545.44
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-310,490,936.86	-154,918,545.44
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,555,873,519.38	1,760,007,471.13
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,555,873,519.38	1,760,007,471.13
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	0.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,580,366,176.87	1,932,254,668.10
1.2.1	Ажиллагчдад төлсөн	621,783,337.89	654,068,895.61
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	172,628,708.43	198,779,884.38
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	234,043,182.00	313,167,960.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	245,356,646.48	350,198,406.66
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	73,220,106.00	192,937,756.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	33,592,000.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	97,343,723.73	143,748,091.26
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,489,550.00	580,987.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	100,908,922.34	78,772,687.19
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-24,492,657.49	-172,247,196.97
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,472,305.66	20,174,672.57
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	8,472,305.66	20,174,672.57
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00

2.1.8	Бусад	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	91,705,749.00	0.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	81,805,749.00	0.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,900,000.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.2.6	Бусад	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-83,233,443.34	20,174,672.57
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Бусад	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	68,000,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Бусад	0.00	68,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	-68,000,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-107,726,100.83	-220,072,524.40
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	426,832,259.51	319,106,158.68
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	319,106,158.68	99,033,634.28

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Өмч	Хөрийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	351,271,342.52	206,573,729.30	3,395,610,000.00	1,282,937,547.01	2,670,517,524.81
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	455,893,634.08	455,893,634.08
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-310,490,936.86	-310,490,936.86
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	351,271,342.52	206,573,729.30	3,395,610,000.00	1,137,534,849.79	2,815,920,222.03
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	308,235,448.62	308,235,448.62
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00

12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-154,918,545.44	-154,918,545.44
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	176,738,601.00	0.00	176,738,601.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	351,271,342.52	206,573,729.30	3,572,348,601.00	-984,217,946.61	3,145,975,726.21

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар 83,955.4 мянган төгрөгийн алдаа¹ 3 алдаа илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд:

- Бусад авлагыг 7,487.3 мянган төгрөгөөр кредит үлдэгдэлтэй тайлагнаж авлагын дүнг бууруулсныг аудитын явцад залруулав. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” гэсэн заалт болон аудитын Үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна
- Дансны өглөгийг 1,000.0 мянган төгрөгөөр, бусад богино хугацаат өр төлбөр 7,468.1 мянган төгрөг дебет үлдэгдэлтэй тайлагнаж өр төлбөрийн дүнг бууруулсныг аудитын явцад залруулав. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 “ 14.4.3 бүх өр төлбөрийг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” гэсэн заалт болон аудитын үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна
- Бусад урт хугацаат өр төлбөрийг 68,000.0 мянган төгрөгөөр бууруулан тайлагнасныг аудитын явцад залрууллаа. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 “ 14.4.3 бүх өр төлбөрийг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” гэсэн заалт болон аудитын үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Аудитаар залруулагдаагүй нийт 67,733.5 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 640.0 мянган төгрөгт 1 төлбөрийн акт, 67,093.5 мянган төгрөгт 5 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Албан томилолтоор явсныг нотлох баримт буюу албан томилолтын хуудасгүй байхад 4 албан хаагчид нийт 640.0 мянган төгрөгийн томилолтыг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. Тайлант онд тооцоо нийлсэн актаар баталгаажгаагүй 26,599.9 мянга, (нийт 59,201.5 мянган төгрөгөөс хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа 32,601.6 мянган

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөгийн авлагыг хассан дүнгээр) тооцоо нийлж баталгаажуулсан 12,489.2 мянга, нийт 39,089.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.2.2. Тайлант онд 5,232.4 мянган төгрөгийн шатахууныг байгууллагын удирдлагын автомашинд зарцуулсан бөгөөд жолоочийн тооцооны хуудсыг хөтлөөгүй, түүнд хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5.-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” -ын 6 дугаар зүйлийн 6.4-т заасан жолоочийн тооцооны хуудас нөхөх зааварт “хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна, тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр шатахууны хэтрэлт, хэмнэлтийг гаргана” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдад олгох ХХОАТ-ын сүүлийн 2 жилийн буцаалт 7,468.1 мянган төгрөг, НӨАТ-ын өглөг 15,191.9 мянган төгрөг, 2 жилийн насжилттай хувь хүнд төлөх 112.0 мянган төгрөг, нийт 22,772.0 мянган төгрөгийг өр төлбөрийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2.4 Тус байгууллага нь тайлант онд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ын 3.1. “Энэхүү журмын 1.3-т заасан “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан ... гүйцэтгэнэ”, 3.4-д “Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.2.5 Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг хянаж үзэхэд анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан 40 нэр төрлийн 158,660.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 13 нэр төрлийн 17,849.0 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл, 36 нэр төрлийн 90,029.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 266,359.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан, ... эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.2 "... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.1." Төрийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах саналаа энэ журамд заасан баримт материалын хамт хагас жилд 1 удаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ", 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", 7.2-т "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталж, данснаас хасахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авсан боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн тогтоож, дахин данс бүртгэлд тусгана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

3.3.1 Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийт орлогыг 1,803,279.7 мянган төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 1,601,387.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 11.2 хувиар тасалсан байна.

Энэ нь Ар Ус Ундарга ОНӨХХК -ний ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 08-ны 01 дүгээр тогтоолын 1, 2 дахь заалттай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Орлогыг бодит тоо, мэдээ судалгаанд үндэслэн оновчтой төлөвлөж, орлогыг төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлж байна.

3.3.2 Шатахуун зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагад ашиглагдаж байгаа цэвэр ус зөөврийн 2, бохир ус зайлуулах 2, ачаа тээврийн 1 автомашин нь элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, олон жил ашиглагдаж, спидометрийн заалтууд ажиллахгүйгээс шалтгаалж, жолоочийн тооцооны хуудсыг хөтлөөгүй байна.

Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Автомашин шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж"-ийн 3-т "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд боломжтой гэж үзвэл үндсэн нормоор нь шууд мөрдөх, эсвэл тодорхой хугацаанд тухайн автомашины шатахуун зарцуулалтад хэмжилт, туршилт явуулсны үндсэн дээр өөрийн ажил, үйлчилгээний онцлог, авто замын болон цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан нэмэгдүүлэх ба хорогдуулах замаар үндсэн норм болгож мөрдөж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Автомашин шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж"-ийн дагуу холбогдох арга хэмжээг авч, шатахуун зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 22-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, холбогдох нотлох баримтын хамт 2024 оны 12 дугаар сарын 05-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

.....оОо.....

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлагыг бууруулж бүртгэсэн	1	7487.3			1	7487.3	1	7487.3				
Өр төлбөрийг бууруулж бүртгэсэн	1	8468.1			1	8468.1	1	8468.1				
Өр төлбөрийг бууруулж бүртгэсэн	1	68000.0			1	68000.0	1	68000.0				
Нийт	3	83955.4			3	83955.4	3	83955.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтгүй томилолт олгосон	1	640.0	1	640.0								
Авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актгүй	1	39089.1			1	39089.1						
Жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй	1	5232.4			1	5232.4						
Жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй	1	0					1	0				
Өр төлбөрийг барагдуулаагүй	1	22772.0			1	22772.0						
Дотоод хяналт хэрэгжүүлээгүй	1	0			1	0						
Анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгөд холбогдох арга хэмжээ аваагүй	1	0			1	0						
Орлогыг бодитой төлөвлөөгүй	1	0					1	0				
	7	67733.5	1	640.0	5	67093.5	2	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай тогтоомжтой холбоотой зөрчил								
Мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн	1	0	0	0	1	0	0	0
	1	0	0	0	1	0	0	0